# БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 03 сарын 25-ны өдөр Дугаар БА-089/2025 Улаанбаатар хот

## Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой, 2 блок, 272 (хоёр зуун далан хоёр) автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 (хоёр зуун ерин зургаа) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 сарын 28-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

## Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2025/02/07 огноо, дугаар БАЗГ2025/0043

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: BSD-08/2019

2.3. Захиалагч: Саруул шилтгээн констракшн ХХК, /9011413029/ Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, /5585465/ регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 6-р хороо их сургуулийн 32/1-901, холбоо барих утас: 77557070, 88881200 цахим хаяг: info@ssc.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Саруул шилтгээн констракшн ХХК, /9011413029/ Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, /5585465/ регистрийн дугаар, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ16-176/21, Хаяг: Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 6-р хороо их сургуулийн 32/1-901, холбоо барих утас: 77557070, 88881200 цахим хаяг: info@ssc.mn

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Жи Ди Эйч ХХК, 9011380133 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5659256 регистрийн дугаар, БУ17-637/19 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаартай, СХД 11-р хороо 3-157 тоот Хаяг: 99995828 холбоо барих утас, цахим хаяг: gdh.mongolhhk@gmail.com

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: "Би И Эс Ай Жи Эн" ХХК, 9011214005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5336058 регистрийн дугаар, ЗТ12-56/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаартай, СБД 6-р хороо АБ центр Хаяг: 89008005 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Саруул шилтгээн констракшн ХХК, /9011413029/ Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, /5585465/ регистрийн дугаар, БУ16-176/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 6-р хороо их сургуулийн 32/1-901, холбоо барих утас: 77557070, 88881200 цахим хаяг: info@ssc.mn

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

☑ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зоорьтой, 2 блок, 272 (хоёр зуун далан хоёр) автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 (хоёр зуун ерин зургаа) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:
Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:
   а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
   б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

   а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

## Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Энэ өндөр төвөгшилтэй зоорьтой, 2 блок, 272 (хоёр зуун далан хоёр) автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 (хоёр зуун ерин зургаа) айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах, комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, өндөр төвөгшилтэй ангиллын айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Саруул шилтгээн констракшн ХХК-ийн захиалгатай, зоорьтой, 2 блок, 272 (хоёр зуун далан хоёр) автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 (хоёр зуун ерин зургаа) айлын орон сууц

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Саруул шилтгээн констракшн ХХК-ийн гүйцэтгэх захирал (Т.Алтгангэрэл)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САН БҮРТГЭВ.
Объектын дугаар: 76
Огноо: 2025 он 03 сар 26 өдөр
Бүртгэсэн:
УЛААНБААТАР ХОТ ГТМ №1584

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19 ДҮГЭЭР ХОРОО, САРУУЛ ШИЛТГЭЭН КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ, 2 БЛОК, 272 АВТОМАШИНЫ НЭГДСЭН ЗОГСООЛ, 2 ДАВХАР 2 БЛОК, ҮЙЛЧИЛГЭЭ, 16 ДАВХАР, 2 БЛОК, 296 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 28 Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Саруул шилтгээн констракшн ХХК-ийн захиалгатай, зоорьтой, 2 блок, 272 автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 98/2-р байрны 3 дугаар давхрын 306 тоот өрөөнд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 11 цагт 15 минутанд комиссын гишүүдийн бүрэлдэхүүнтэй эхэлж, 16 цагт дуусав.

Хуралд:

| | | |
|---|---|---|
| 1. | Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн |
| 2. | Комиссын нарийн бичгийн дарга: Саруул шилтгээн констракшн ХХК-ийн гүйцэтгэх захирал | Т.Алтангэрэл |
| 3. | Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Ц.Алтансүх |
| 4. | Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч | Э.Цогзолмаа |
| 5. | Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга | Д.Сүхбат |
| 6. | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын /ахлах/ инженер | Ц.Наранцацрал |
| 7. | Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК-ийн Технологийн төлөвлөлтийн газар, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн | Э.Уранчимэг |
| 8. | Ус сувгийн удирдах газар, Шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер | Д.Болормаа |
| 9. | Онцгой байдлын ерөнхий газар Барилгын зураг төсөл техникийн гүйцэтгэл хариуцсан ахлах мэргэжилтэн /Дэд хурандаа/ | М.Батсайхан |
| 10. | Үндэсний Төв Архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 11. | Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн | Б.Жаргал |

12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл Б.Ганбаатар
13. Ашиглалт хариуцах байгууллага, Голд Компасс ХХК-ийн Ерөнхий инженер н.Энхбаяр
14. Зураг төсөл зохиогч байгууллага, Бизайн ХХК-ийн захирал Т.Хасбаатар
15. Барилгын ажил гүйцэтгэгч, Саруул шилтгээн констракшн ХХК-ийн Ерөнхий инженер Т.Дорлигжав

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн -15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Саруул шилтгээн констракшн ХХК-ийн захиалгатай, зоорьтой, 2 блок, 272 автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 айлын орон сууцны зориулалттай барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Ц.Алтансүх**

- “В” блок дутуу тул хасах саналтай
- А’ Б’ А Б Г Д блокын дутуу ажлуудыг гүйцээх
- А’ Б’ блок болон А Б блокын үйлчилгээний ажлын дутуу гүйцэтгэлийг хангуулах
- БАЗГ шалгуулах
- Ил далд ажлын актыг, барилгын ажлын /зөвшөөр/ журналыг уялдуулах биелэлтийг хангуулах
- Хөндлөнгийн байгууллагын дүгнэлтүүдийг шалгуулах,(Бетоны гэрчилгээний хамт)
- Нийтийн эзэмшлийн талбай, айл хооронд хананд цууралт ан цав, хагарал үүссэн байгааг засварлах
- Дутуу ажилд гүйцэтгэлийн шалгалт хийх
- Хөрсний уснаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан баримтыг шалгуулах
- БТХ-ийн 11-р зүйлийн 11.1.1 дэх заалтыг бүрэн хангуулах
  (Ажлын 14 хоногт багтаах)

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барил

Барилгын хөгжлийн төв, Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн, Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн **Б.Жаргал**

- Барилгын тухай хуулийн дагуу норм, норматвын санд төлбөр төлөх
- Айл өрхийн цонхны нээлхий болгонд бүрэн бат бэх хамгаалалт хийх
- Барилгад ашиглсан барилгын материалуудын гарал үүслийн гэрчилгээ, лабарторуудын шилжилгээний дүн
- Агаарын орчны шинжилгээг хийлгэх /Бүх давхар/
- Талбайн журнал, ил далд ажлын актыг нөхөж үзүүлэх
- Орцны хананд 1.8-2м өндөртэй хэсгийн тосон будгаар будах шаардлагатай

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- Дулааны узелийн өрөөг хаягжуулах
- Холигч насосны узелийн өрөөг хаягжуулах
- А,Б блок байрны дээвэр дээрх АС-н шахтнаас бохирын хоолойг өндөрлөх
- Айл өрхийн зарим халаах хэрэгслүүд дутуу байна, үүнийг гүйцээх тормастат винтель суурилуулах
- АС-н системийн бүрэн угсарч хэвийн ажиллагаанд оруулж баталгаа албан тоот ирүүлэх
- Барилгын тухай хуулийн зүгшрүүлэх, тохируулах чанарын баталгааны албан тоот ирүүлэх УБДС ТӨХК-аас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Давхрын тоолуурын коллектрыг хаягжуулах

Санал: Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

УБЦТС ТӨХК, Техник хяналтын /ахлах/ инженер **Ц.Наранцацралт**

- ТН-15/01094/22-ын 1.5 дах, 3-р заалтыг тодруулах
- Аянга хүлээн авагч хийх, хүрээг гүйцээх
- Давхар дундын шийдтэнд тоолуур харах цонх хийх
- Узель 6, Лифтний өрөөний газардуулгын хүрээг гүйцээж, тоноглолыг холбож өгөх
- Цахилгааны ерөнхий шийтийг хөдөлгөөнгүй бэхлэж схем, хаягжуулалтыг хийх, 00-н клемийг ААД-т нийцүүлэн угсрах
- Дизель генераторыг ДА-нд бүртгүүлах
- А Б блокын үйлчилгээний давхрын шийтний угсралтын гүйцээж тоолуур тавих
- Ил далд ажлын акт огноо, гүйцэтгэгчийн гарын үсгийн бүрдэл дутуу
- Дэд өртөөний 0.4кв-т талын өрөөний газардуулгын хүрээг гүйцээж хийх
- 0.4кв кабелийн ил далд ажлын актыг нөхөж үзүүлэх
- Барилга баригдах үеийн төлбөр тооцоог барагдуулсан байх, үндсэн тэжээлийн лацгүй тоолуур, лацдуулах

Үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, байнгын ашиглалтанд оруулах саналыг дэвшүүлж байна.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар, Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Э.Уранчимэг**

- Давхрын самбаруудыг хаягжуулж биркжүүлэх
- Зарлал мэдээлэх системийн микрофоныг зориулалтын тавиурт байршуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

УС сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Д.Болормаа**

- БУХ 5-аас холболтын худаг хүртэл шугам угсралтын далд ажлын акт баталгаажуулах
- Гадна цэвэр, усны ажлын зургаас шугамын трасс өөрчлөгдсөн
  -Өөрчлөлтийн зураг батлуулах
  -Далд ажлын акт баталгаажуулах
- Нөөцийн савны хэмжээг багасган110м.куб суурилуулсан байна. Батлагдсан зургийн дагуу суурилуулах
- БУ-ны худгуудын хүзүүвчийг тоосгоор өрснийг засаж янзлах
- 365/22 дугаартай техникийн нөхцлийн шаардлагын дагуу гадна ЦУХ-т галын гидрант суурилуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчдийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат**

- Халаах хэрэгсэл тохируулах
- Винтел хийх
- Хамгаалалтын зурваст албан тоот өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг /Дэд хурандаа/ **М.Батсайхан**

- Шаталтын бүтээгдэхүүн сорох системийн автомат хавхлагыг гүйцээж хийх
- Утаа хаях хэсгийг өгдөрлөх (2м)
- 1-р давхрын авто зогсоол хэсгээс нийтийн эзэмшил болон үйлчилгээ рүү орох хэсгийн хаалгыг галд тэсвэртэй хаалгаар солих
- Зоорийн давхрын авто зогсоолд галын хөшиг хийх, мөн 1-р давхар луу гарах пандусын хэсэгт хийх
- Барилгын гадна ханаы гал тэсвэржилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт нөхөж үзүүлэх
- ГК гал унтраах дотор усны даралтат цэгийн холбох хэрэгслийг “БОГДАНОВ” төрлийн болгох
- Гал түймрийн үед ашиглах, галын гадна гидрант хийх
- Дутуу хийгдсэн галын дохиолол мэдээлэгчийг хийх
- Гал унтраах автомат төхөөрөмжийг туршиж шалгаад видео бичлэгээр ирүүлэх

- Үүрэг даалгаврын биелэлтийг фото зураг, видео бичлэгээр баталгаажуулах, албан бичгээр ирүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгуулагын төлөөлөл Б.Ганбаатар

- Орцнууд руу орсон налуу замын нэг талд нэмж нэг бариул хийх
- Ашиглалттай талбай руу гарсан налуу замын 2 талын бариулыг гарт эвтэй дугуй материалаар солих
- Үйлчилгээний урд зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөнийг 3м 95см машин зогсох зай 2м 45см тэргэнцэртэй бууж суух зай 1м 50см эргэх шугам татаж тусгаарлаж өгөх
- Зогсоолын урд 1м 30 см мөн 30 см 45 см багагүй самбар хийж өгөх
- Үйлчилгээний заалнуудад зориулсан 1,2 дугаар давхруудын нийлээд 12ш ариун цэврийн өрөөнд БНбД 31-23-22 стандартын шаардлага хангасан туслах тоноглолыг суурилуулна

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун**

- Тус барилгын баримт бичгийг архивын зааврын дагуу төрөлжүүлж цэгцлэх, дотоод товьёог үйлдэх, хуудас дугаарлах
- Ажлын зураг болон үндсэн баримтын эх хувийг архивд хүлээлгэж өгөх
- Баримт бичгийн бүрдэлийг сайтар анаарч бүрдүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Комиссын нарийн бичгийн дарга: Саруул шилтгээн констракшн ХХК-ийн гүйцэтгэх захирал **Т.Алтангэрэл**

- Байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч: Бизайн ХХК-ийн захирал **Т. Хасбаатар**

- Бүх гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага Саруул шилтгээн констракшн ХХК-ийн Ерөнхий инженер **Т.Дорлигжав**

- Байнгын ашиглалтанд оруулах саналтай байна

Ашиглалтад хариуцах байгууллага: Голд Компас ХХК-ийн Ерөнхий инженер **М.Энхбаяр**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- БТХ-ийн 14.3, 14.6 зүйл заалтын дагуу гүйцэтгэгч компани барилгад чанарын баталгааны албан тоот ирүүлэх

- А' , Б' үйлчилгээний хэсгийн заслын ажлыг бүрэн дуусгах
- Дээврийн мембрамын ажлыг хийх, ус зайлуулах хоолойг доош нь буулгах
- Авто зогсоолын шилэн хаалгыг металл хаалгаар солих
- Нийтийн эзэмшлийн хаалганы налууг хийх
- Үйлчилгээний хэсгийг дүгнэлт албажсаны дараа ашиглах, албан тоот ирүүлэх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу тохижолт, ногоон байгууламжийн ажлыг бүрэн хийж дуусгах, хугацаатай албан бичиг ирүүлэх
- ЗГ-ын 2021 оны 212 тогтоолын 8.1 дэх заалтыг чанд баримтлах

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Саруул шилтгээн констракшн ХХК-ийн захиалгатай, зоорьтой, 2 блок, 272 автомашины нэгдсэн зогсоол, 2 давхар 2 блок, үйлчилгээ, 16 давхар, 2 блок, 296 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Саруул шилтгээн констракшн ХХК-ийн
Гүйцэтгэх захирал (Т.Алтангэрэл)